

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Хутаг-Өндөр суман дахь сум дундын ойн ангийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ХУРААНГУЙ тайлан

**Аудитын код: БУА-2026/11/НА-СТА-ОНӨҮГ**

---

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт  
Утас: 70342580 Цахим хаяг: [Battsogtd@audit.gov.mn](mailto:Battsogtd@audit.gov.mn)  
Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 70342495 Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)  
Аудитор: Б.Энхтөр  
Утас: 70342495 Цахим хаяг: [enkhturb@audit.gov.mn](mailto:enkhturb@audit.gov.mn)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.03.03 № 291  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ХУТАГ-ӨНДӨР СУМ ДАХЬ  
СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН  
ДАРГА Э.МӨНХ-ЭРДЭНЭ  
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хутаг-Өндөр сум дахь Сум дундын ойн ангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хутаг-Өндөр сум дахь сум дундын ойн ангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус газар нь тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 171.7 сая төгрөгийн төсөв баталж, үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогоос 21.0 сая төгрөгөөр төлөвлөж дээд шатны байгууллагад хүргүүлж байна.

Гүйцэтгэлээр Орон нутгийн төсвөөс 112.3 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 147.9 сая төгрөгийг зарцуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 21.0 сая төгрөгийн зарцуулах эрх авч 34.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж оны эцэст орон нутгийн төсөвт 15.2 сая төгрөгийн хэмнэлт гарган татан төвлөрүүлж ажилласан байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

**Бусад мэдээлэл**

6326050422

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.  
Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	22,876.19	38,454.17
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	59,592.66	50,670.62
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>82,468.84</b>	<b>89,124.79</b>
	Нийт өр төлбөрийн дүн	0	0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	82,468.84	89,124.79
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>82,468.84</b>	<b>89,124.79</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	174423.6289	207649.7822
	Үйл ажиллагааны зардлын дүн	188385.7415	178820.1128
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>-13962.11257</b>	<b>28829.66937</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	-128.33	-25,551
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>-14,090.45</b>	<b>3,278.54</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,559.29	82,424.84
	Тайлант оны үр дүн	0	3,278.54
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>82,468.84</b>	<b>89,124.79</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	169,917.43	173,903.38
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	168,597.43	166,583.28
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>1,320</b>	<b>7,320</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>-1,320</b>	<b>-7,320</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>		
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>192,621</b>	<b>147,883.51</b>
	Урсгал зардал	192,621	147,883.51
	Хөрөнгийн зардал	0	0
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>0</b>	<b>0</b>
	Улсын төсвөөс санхүүжих	0	0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0	112,300

### Гурав: Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Хөдөө аж ахуй, хөгжлийн ирээдүй” ОНӨХХК-ний зорилго нь Улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээс нийлүүлэгдсэн хөрөнгө оруулалтаар иргэн, аж ахуйн нэгжийн орлого, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, шинэ технологи, инновацыг нэвтрүүлэх, аймгийн мал сүргийн бүтцийг сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлэх, цаг үеийн онцгой байдал, гамшгийн үед хэрэгцээтэй хүнс, малын тэжээл, өвс, шатахуун, орон гэр, хамгаалалтын хувцасны нөөцийг бэлтгэх, стандартын дагуу хадгалж, шаардлагатай үед хэрэгцээтэй газруудад түгээх, худалдан борлуулах, нөхөн бэлтгэх замаар компанийн тогтвортой үйл ажиллагааг ханган ажиллахад оршино.

### Дөрөв: Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус газар нь тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 171.7 сая төгрөгийн төсөв баталж, үндсэн үйл ажиллагааны өөрийн орлогоос 21.0 сая төгрөгөөр төлөвлөж дээд шатны байгууллагад хүргүүлж байна.

Гүйцэтгэлээр Орон нутгийн төсвөөс 112.3 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 147.9 сая төгрөгийг зарцуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 21.0 сая төгрөгийн зарцуулах эрх авч 34.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж оны эцэст орон нутгийн төсөвт 15.2 сая төгрөгийн хэмнэлт гарган татан төвлөрүүлж ажилласан байна.

#### **Тав. Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

#### **Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүйгээс 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээсэн.

#### **Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн оруулах, төсвийг зохистой удирдах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

#### **Найм. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 15,444.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 105.0 мянган төгрөгийн 1 залруулга, 15,339.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн зөрчлөөс материаллаг 195.0 мянган төгрөгийн залруулагдаагүй 2 зөрчил, 2,371.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж нь материаллаг бус зөрчил байна. Иймд аудитаар тогтоосон материаллаг байдлын түвшингөөс 1,701.7 мянган төгрөгөөр бага байгаа тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### **8.1 Төлбөрийн акт**

#### **8.2 Албан шаардлага бичигдээгүй**

#### **8.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Шилэн данстай холбоотой**

##### **Илрүүлэлт:**

Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллаагүй мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн мэдээлээгүй.

##### **Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

##### **2. анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой**

##### **Илрүүлэлт:**

СДОА-ийн албан хаагчид Хялганат тосгонд туршлага солилцох ажлаар 1 албан хаагч ажилласан боловч анхан шатны баримтын бүрдэл дутуу.

**Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

**3. Авлагатай холбоотой**

**Илрүүлэлт:**

Нийгмийн даатгалаас авах 333.7 мянга, төлбөртэй үйлчилгээ 4,995.0 мянга, байгууллагаас авах 7,550.1 мянга нийт 12,878.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулах.

**Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ойгоос хэрэглээний мод бэлтгэх 700 ширхэг гоожинг орлогот аваагүй шууд зарцуулсан	1	105.0	1	105.0			1	105.0				
	1	105.0	1	105.0			1	105.0				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
СДОА-ийн албан хаагчид Хялганат тосгонд туршлага солилцох ажлаар 1 албан хаагч ажилласан боловч анхан шатны баримтын бүрдэл дутуу.	1	90.0					1	90.0				
Нийгмийн даатгалаас авах 333.7 мянга, төлбөртэй үйлчилгээ 4,995.0 мянга, байгууллагаас авах 7,550.1 мянга нийт 12,878.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулах.	1	12,878.8					1	12,878.8				

Дүн	2	12,968.8				2	12,968.8			
-----	---	----------	--	--	--	---	----------	--	--	--

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллаагүй мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн мэдээлээгүй.ажиллаагүйгээс 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээсэн.	1	2,371.0			1	2,371.0
Дүн	1	2,371.0			1	2,371.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						